

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ:
ИРМҮҮН БАРМАТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Н. ЗОРИГТБААТАР



УС ЗӨӨЛРҮҮЛЭХ ТӨХӨӨРМЖИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ ХУДАЛДАХ,

ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 09/2022

2022 оны 07 сарын 08 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.БАЯНМӨНХ нөгөө талаас Ирмүүн бармат ХХК-ийг төлөөлж захирал Н.Зоригтбаатар /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрийн 2021 оны 124 дүгээр тогтоол, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь ”Ус зөөлрүүлэх итхөөрөмжийн удирдлагын систем” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 45 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 14,000,000 /арван дөрвөн сая/ төгрөг бөгөөд үнийн дүнд Гааль, Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсан өдөр төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5028195402 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь

гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3 Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Нэгдсэн цехийн химийн инженер Д.Хишигшинэн хариуцан ажиллана. Утас-88100929.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Ирмүүн бармат ХХК-ийн захирал Н. Зоригтбаатар хариуцан ажиллана. Утас- 88113890.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед эвдэрч гэмтэхээс хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согогийг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.
- 5.6 Барааг дараах бичиг баримт дагалдана.
 - Чанарын стандартын гэрчилгээ
 - Үйлдвэрлэгчийн паспорт

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 5 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл


- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө.
Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.


Ес. Бусад нөхцөл


- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ө. УДВАЛ
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г. ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 

НЭГДСЭН ЦЕХИЙН ДАРГА
Ж. АРИУНЖАРГАЛ
Гарын үсэг: 

ХИМИЙН ИНЖЕНЕР
Д. ХИШИГШИНЭН
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г. САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш. ГАНТУЛГА
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ИРМҮҮН БАРМАТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Н. ЗОРИГТБААТАР
Гарын үсэг:



Хаяг: Улаанбаатар хот БЗД 31-р хороо
14-р хороолол 99-р байр 108 тоот
Утас: 70087009
РД: 2823969

тоот гэрээний хавсралт

Ус зөөлрүүлэх төхөөрөмжийн удирдлагын систем болон бусад хэрэгсэл нийлүүлэх үнийн хуваарь

Д/д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нэгжийн үнэ	Нийт НӨАТ-тэй үнэ
1	Удирдлагын систем	ком	1	14,000,000	14,000,000
2	Загвар		63650 F96A3		
3	Хүчин чадал	тн/ц	50		
4	Ажлын даралт	Мра	0,2-0,6		
5	Шугамын диаметр	мм	80		
6	Нийт дүн				14,000,000

Амгалан дулааны станц ТӨХК нэгдсэн цехийн дарга



Ж. Ариунжаргал

Ирмүүн бармат ХХК-ийн захирал



Н. Зоригтбаатар